



ГОЛОМТ БАНК

Сайн сайхныг санхүүжүүлнэ

**ГОЛОМТ БАНК ХК-ИЙН 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
Тайлагнах хугацаа	2026.01.01 - 2026.06.30
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Нэр: Голомт банк ХК РД: 2075377 Хаяг: Голомт банкны Төв байр, Д.Сүхбаатарын талбай 5, Ш/х-22 Улаанбаатар 15160, Монгол улс Утас: 1800-1646 (24/7) 7011-1646 (Дотуур утас) Факс: 11-313155 И-мэйл: investornews@golomtbank.com Веб сайт: www.golomtbank.com
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	808,657,306 ширхэг
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн: Б.Үнэнхүү /Хөрөнгө оруулалтын менежер/ Тайлан хянасан: З.Солонго /ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга/

1	Хагас жилийн санхүүгийн тайлан		
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН			
	Балансын зүйл	31/12/2025	30/06/2026
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6,834,276,445,451.72	5,945,789,219,371.09
1.1.1	Бэлэн мөнгө	139,582,917,387.88	146,089,492,575.0
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	4,400,051,494,455.39	3,595,573,654,314.39
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	2,294,096,752,568.74	2,203,844,452,559.22
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	545,281,039.7	281,619,922.48
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	1,247,300,903,831.14	1,383,349,545,073.52
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	763,190,767,562.01	892,916,419,117.36
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	485,399,000,668.92	488,098,511,494.13
1.2.3	Бусад хөрөнгө	-	-
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,145,058,635.15	4,768,537,496.97
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	(2,433,923,034.94)	(2,433,923,034.94)
1.3	Хөрөнгө оруулалт	1,585,519,473,310.19	2,369,232,460,380.19
1.3.1	Арилжааны үнэт цаас	307,967,088,334.00	502,020,951,794.33
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	771,538,876,339.49	700,548,895,603.08
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	196,173,200,000.00	196,173,200,000.00
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	-	-
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	-	-
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	238,296,220,000.00	939,779,600,000.00
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	36,311,961,823.86	38,215,961,561.55
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	35,232,126,812.85	(7,506,148,578.77)
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	8,166,178,564,010.99	8,730,129,721,924.81
1.4.1	Хэвийн зээл	7,856,720,359,660.43	8,482,996,230,993.13
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	186,007,724,919.69	150,009,074,408.93
1.4.3	Хэвийн бус зээл	42,651,196,380.42	44,560,007,394.46
1.4.4	Эргэлзээтэй зээл	71,023,626,655.78	57,397,414,740.41
1.4.5	Муу зээл	96,453,524,837.79	120,718,759,134.31
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	(29,468,209,157.09)	(33,740,527,025.76)

1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	94,798,113,411.39	68,196,010,362.54
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	(152,007,772,697.41)	(160,007,248,083.21)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	260,415,142,573.93	327,121,557,555.91
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	77,042,815,429.07	19,409,949,753.83
1.6.1	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)	39,061,441,853.88	11,468,222,996.60
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	2,222,250,522.30	1,769,120,171.27
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	-
1.6.4	Бусад	35,759,123,052.89	6,172,606,585.96
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	560,739,487,355.48	149,467,092,243.99
1.7.1	Бусад тооцоо	532,791,029,564.34	42,340,168,530.97
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	8,512,036,188.56	7,800,928,791.25
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	608,268,486.22	60,121,035,452.06
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	-	26,586,187,029.67
1.7.5	Татварын авлага	14,092,503,783.73	6,300,000,000.00
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.7.7	Бусад	4,735,649,332.63	6,318,772,440.04
1.8	Үндсэн хөрөнгө	204,752,688,877.00	765,623,426,373.74
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	9,063,987,911.72	9,063,987,911.72
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	211,372,165,765.29	135,046,439,721.84
1.11	Биет бус хөрөнгө	26,267,201,691.93	25,534,130,900.88
	Нийт хөрөнгийн дүн	19,182,928,876,208.50	19,859,767,531,211.50
2	ӨР ТӨЛБӨР		
2.1	Харилцах	3,886,415,279,580.23	4,866,474,729,537.35
2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	3,886,362,019,795.32	4,866,289,308,501.84
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	53,259,784.91	185,421,035.51
2.2	Хадгаламж	5,969,473,651,002.30	6,182,733,078,912.35
2.2.1	Хугацаагүй хадгаламж	634,206,281,187.56	675,691,945,436.54
2.2.2	Хугацаатай хадгаламж	5,085,457,448,369.94	5,258,549,975,860.03
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	50,244,919,649.46	2,702,081,085.62
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	199,565,001,795.35	245,789,076,530.16
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	4,278,158,846,657.30	3,107,659,372,939.83
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	1,247,953,195,827.94	980,948,799,086.24
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	3,032,026,985,209.68	2,123,259,938,894.45
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(12,668,518,548.11)	(12,745,506,731.68)

2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	10,847,184,167.79	16,196,141,690.82
2.4	Бусад эх үүсвэр	3,076,805,321,206.49	3,692,983,836,904.99
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	1,908,336,832,149.15	2,903,186,985,409.98
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	-	0.00
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	191,657,861,608.76	202,035,702,823.62
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)	397,561,282,463.21	0.00
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	51,216,960,304.93	75,353,226,112.80
2.4.6	Бусад	521,617,766,030.36	502,303,378,430.72
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	(14,818,893,699.46)	(18,021,309,549.45)
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	21,233,512,349.54	28,125,853,677.33
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	24,854,013,540.39	11,764,073,349.76
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	152,036,179,053.60	145,593,679,892.73
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	109,526,105,985.35	121,044,140,595.17
2.8	Хоёрдогч өглөг	-	0.00
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	-	0.00
	Нийт өр төлбөрийн дүн	17,497,269,397,025.70	18,128,252,912,132.20
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	202,164,326,500.00	202,164,326,500.00
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	-	0.00
3.1.2	Энгийн хувьцаа	202,164,326,500.00	202,164,326,500.00
3.2	Нэмж төлөгдсөн капитал	301,481,119,995.04	301,481,119,995.04
3.3	Халаасны хувьцаа	-	0.00
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	14,475,354,796.75	14,475,354,796.75
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,082,530,281,096.43	1,128,362,519,327.39
3.6	Бусад өөрийн хөрөнгө	85,008,396,794.59	85,031,298,460.16
3.6.1	Хувьцааны опцион	-	0.00
3.6.2	Нөөцийн сан	658,858,558.78	648,793,565.11
3.6.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сан	-	0.00
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	69,170,490,890.35	69,170,490,890.37
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	-	0.00
3.6.6	Хөрвөх өр төлбөр	-	0.00
3.6.7	Хувьцааны баталгаа бүхий зээл	-	0.00
3.6.8	Бусад	15,179,047,345.46	15,212,014,004.68
	Өөрийн хөрөнгийн дүн	1,685,659,479,182.81	1,731,514,619,079.34
	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	19,182,928,876,208.50	19,859,767,531,211.50

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Он/сар/өдөр

2026/06/30

	Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Хүүгийн орлого	1,475,595,615,941.78	850,240,558,025.39
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	12,640,138,696.87	7,923,902,886.01
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	8,412,641,386.85	12,696,527,740.99
1.3	Үнэт цаасны	218,120,886,378.94	191,648,974,613.14
1.4	Зээлийн	1,213,485,224,242.10	622,171,579,731.84
1.5	Бусад хүүгийн орлого	22,936,725,237.02	15,799,573,053.41
2	Хүүгийн зардал	874,359,939,651.90	704,105,695,062.89
2.1	Харилцахад төлсөн хүү	37,422,666,911.24	32,557,061,409.18
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	565,880,403,748.37	331,215,963,870.32
2.3	Зээлийн хүүгийн зардал	66,312,692,112.13	54,848,139,802.39
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	182,040,776,945.52	145,608,132,028.49
2.5	Бусад хүүгийн зардал	22,703,399,934.64	139,876,397,952.50
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	601,235,676,289.89	146,134,862,962.51
4	Эрсдэлийн сангийн зардал	(38,791,754,933.96)	14,020,235,018.35
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	537,342,628.97	-
4.2	Үнэт цаасны	(2,255,807,408.85)	-
4.3	Зээлийн	(37,073,290,154.08)	14,020,235,018.35
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	640,027,431,223.84	132,114,627,944.16
6	Бусад орлого	315,854,619,454.30	274,234,925,064.35
6.1	<i>Хүүгийн бус орлого</i>	283,757,558,142.75	266,813,095,811.91
6.1.1	Арилжааны орлого	112,514,458,464.33	62,152,240,808.60
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	8,873,976,396.03	87,385,327,115.84
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	143,174,432,590.80	110,242,493,284.11
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	19,194,690,691.58	7,033,034,603.36
6.2	<i>Бусад орлого, олз</i>	32,097,061,311.55	7,421,829,252.44
7	Бусад зардал	551,720,017,178.96	246,776,719,566.58
7.1	<i>Хүүгийн бус зардал</i>	542,705,891,468.31	243,605,827,994.23
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	6,466,864,377.08	1,747,198,179.94
7.1.2	Арилжааны зардал	-	-
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	133,748,632,098.05	38,839,167,973.04
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	95,673,045,469.25	44,895,645,299.96
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	306,817,349,523.93	158,123,816,541.29
7.2	<i>Бусад зардал, гарз</i>	9,014,125,710.64	3,170,891,572.35
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	404,162,033,499.18	159,572,833,441.93

9	Орлогын татварын зардал	73,736,662,500.89	25,326,853,129.07
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	330,425,370,998.29	134,245,980,312.86
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	330,425,370,998.29	134,245,980,312.86
13	Бусад дэлгэрэнгүй орлого	5,624,976,000.00	32,966,659.22
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	-	-
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт	5,624,976,000.00	32,966,659.22
13.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт	-	-
13.4	Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт	-	-
13.5	Бусад	-	-
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (10+11)	336,050,346,998.29	134,278,946,972.08

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

2026/06/30

	Өөрийн хөрөнгийн зүйл	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31 -ний өдрийн үлдэгдэл	202,164,326,500.00	301,481,119,995.04	-	6,186,483,084.69	6,239,461,960.96	753,884,271,777.55	1,269,955,663,318.24
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				8,715,198,544.26	106,973,049,052.23	44,722,149,619.83	160,410,397,216.31
3	Залруулсан үлдэгдэл	202,164,326,500.00	301,481,119,995.04	-	14,901,681,628.95	113,212,511,013.19	798,606,421,397.38	1,430,366,060,534.56
4	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	345,109,310,087.15	345,109,310,087.15
5	Бусад дэлгэрэнгүй орлого					18,798,252.32		18,798,252.32
6	Өмчид гарсан өөрчлөлт					(102,999,581,603.80)	(32,265,995,218.91)	(135,265,576,822.71)
7	Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	-	-	(80,865,730,600.00)	(80,865,730,600.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	(426,326,832.20)	-	568,435,776.28	142,108,944.08
9	2025 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	202,164,326,500.00	301,481,119,995.04	-	14,475,354,796.75	10,231,727,661.71	1,031,152,441,441.90	1,559,504,970,395.40
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					74,776,669,132.88	51,377,839,520.50	126,154,508,653.38
11	Залруулсан үлдэгдэл	202,164,326,500.00	301,481,119,995.04	-	14,475,354,796.75	85,008,396,794.59	1,082,530,280,962.40	1,685,659,479,048.78
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	-	134,245,980,312.86	134,245,980,312.86
13	Бусад дэлгэрэнгүй орлого					32,966,659.22		32,966,659.22
14	Өмчид гарсан өөрчлөлт					(10,064,993.65)	(23,721,157,467.87)	(23,731,222,461.52)
15	Хуваарилсан ногдол ашиг	-	-	-	-	-	(64,692,584,480.00)	(64,692,584,480.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-
17	2026 оны 06-р сарын 30-ний өдрийн үлдэгдэл	202,164,326,500.00	301,481,119,995.04	-	14,475,354,796.75	85,031,298,460.16	1,128,362,519,327.39	1,731,514,619,079.34

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Он/сар/өдөр

2026/06/30

	Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	404,162,033,499.18	159,572,833,441.93
1.2	Орлого, зардлын тохируулга:	(536,327,544,162.87)	(85,022,227,289.85)
1.2.1	Эрсдэлийн сангийн зардал (+)	(32,324,890,678.10)	14,350,010,867.43
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	46,987,562,830.01	16,981,349,591.85
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	77,565,674,409.22	45,981,658,751.26
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	(1,475,595,615,941.78)	(850,240,558,025.39)
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	874,359,939,705.52	704,105,695,062.89
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	(13,272,151,163.70)	(11,890,311,610.80)
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	(14,048,063,324.03)	(4,310,071,927.08)
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:	153,360,630,981.76	(861,854,689,437.66)
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	(135,994,769,092.40)	(136,048,641,242.38)
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	(247,761,572,603.87)	(210,138,867,596.88)
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	(1,283,866,696,485.03)	(444,943,607,601.87)
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	56,182,958,000.00	57,632,865,675.24
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	35,871,725,493.54	(51,728,201,965.57)
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	1,250,219,714,915.50	1,083,775,187,538.44
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	359,642,834,885.88	(1,170,499,473,717.47)
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	72,056,306,009.10	(5,720,599,252.29)
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	47,010,129,859.04	15,816,648,725.13
1.4	Бусад тохируулга:	420,191,819,489.28	79,846,483,855.86
1.4.1	Авсан хүү (+)	1,432,940,884,643.27	713,515,159,783.15
1.4.2	Төлсөн хүү (-)	(949,644,812,173.65)	(635,324,952,005.03)
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	(63,104,252,980.34)	(1,695,842,886.42)
1.4.4	Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	-	3,352,118,964.17
1.4.5		-	-
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	441,386,939,807.35	(707,457,599,429.71)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	116,640,940,000.00	69,382,148,080.89
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	2,119,673,000.00	63,816,750,884.74

2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	375,019,589.61
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	107,422,527,000.00	1,199,551,369.77
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	7,098,740,000.00	14,070,000.00
2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг	-	3,976,756,236.77
2.1.10	Бусад мөнгөн орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(176,634,198,000.00)	(991,072,509,121.82)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	38,999,477,000.00	68,307,945,810.62
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,257,229,000.00	1,614,834,252.60
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	66,626,160,000.00	239,004,179,058.60
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	682,145,550,000.00
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	65,751,332,000.00	-
2.2.9	Бусад мөнгөн зарлага	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(59,993,258,000.00)	(921,690,361,040.93)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,465,832,418,000.00	1,093,143,591,354.02
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	9,465,832,418,000.00	1,093,143,591,354.02
3.1.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	-
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.4	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.5	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(7,978,783,726,000.00)	(329,824,907,398.43)
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	7,878,556,653,000.00	265,132,322,918.43
3.2.2	Хоёрдогч өглөгт төлсөн	-	-
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	19,361,342,000.00	-
3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	-	-

3.2.5	Төлсөн ногдол ашиг	80,865,731,000.00	64,692,584,480.00
3.2.6	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,487,048,692,000.00	763,318,683,955.58
4	Валютын ханшийн зөрүү	(44,757,916,000.00)	(22,657,949,565.58)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,823,684,457,807.35	(888,487,226,080.63)
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,010,591,987,644.36	6,834,276,445,451.72
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,834,276,445,451.72	5,945,789,219,371.09

2	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хурлаар хэлэлцэн баталсан дүгнэлтийг энэхүү тайлангийн Хавсралт №1-ээс дэлгэрэнгүй үзнэ үү.	
3	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт
3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/
Голомт банкны 2026 оны 2-р улирлын санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад: - Нийт актив 4.9 их наяд төгрөг буюу 32.9%-аар өсөж 19.9 их наяд төгрөгт хүрэв. - Нийт зээлийн багц 728 тэрбум төгрөг буюу 9%-аар өсөж, 8.9 их наяд төгрөгт хүрэв. Зээлийн багцын тэнцвэртэй байдлыг хангаж ажилласнаар 55%-г байгууллагын зээл, 45%-г иргэдийн зээл бүрдүүлж байна. - Чанаргүй зээлийн харьцаа 2.5 хувьд хадгалагдсан эерэг үр дүнтэй байна. - Харилцагчийн эх үүсвэр 2.2 их наяд төгрөг буюу 25.3%-аар өсөж 11 их наяд төгрөгт хүрэв. - Хөрөнгө оруулалтын багц 75.5%-аар өсөж, 2.4 их наяд төгрөгт хүрэв. - Нийт өөрийн хөрөнгө 21.1%-аар өсөж, 1.7 их наяд төгрөгт хүрэв. - Татварын дараах цэвэр ашиг 134.2 тэрбум төгрөгт хүрч жилээр илэрхийлсэн дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 16.5% байна. - Монголбанкнаас тавьдаг шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа.	
3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт
2026 оны 6-р сарын 30-ны байдлаар Монголбанкны зохистой харьцаа үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа өмнөх оны эцсээс 0.3%-иар буурч, 15.1%-д хүрлээ. Зохистой харьцаа болох 12%-иас дээш байх шалгуурыг хангаж ажиллаа. I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ	

I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа өмнөх оны эцсээс 0.3%-иар буурч, 15.1%-д хүрлээ. Зохистой харьцаа болох 13%-иас дээш байх шалгуурыг хангаж ажиллаа.

- **Хөрвөх чадварын харьцаа**

Банкны хөрвөх чадварын харьцаа өмнөх оны эцсээс 5.0%-иар өсөж 41.9%-д хүрлээ. Зохистой харьцаа болох 25%-иас дээш байх шалгуурыг хангаж ажиллаа.

Монголбанкны шалгуур	12/31/2025	6/30/2026
Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (>12%)	15.3%	15.1%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа (>13%)	15.3%	15.1%
Хөрвөх чадварын харьцаа (>25%)	36.9%	41.9%
Нэгж гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+15%)	-1.0%	11.2%
Нийт гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+30%)	-2.9%	14.8%
Зээлийн чанар	12/31/2025	6/30/2026
Чанаргүй зээлийн харьцаа	2.5%	2.5%
Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа	101.7%	101.2%

3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл
-----	--

1. Олон улс дахь банкны салбарын голлох өөрчлөлтүүд

2026 оны эхний хагас жилд дэлхийн банкны салбарын хөгжилд геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалсан мөнгөний бодлогын өөрчлөлт, хиймэл оюун ухаан болон дижитал хөрөнгийн хурдацтай хөгжил зэрэг хүчин зүйлүүд зонхилох нөлөө үзүүлэв. Эдгээр өөрчлөлтүүд нь олон улсын санхүүгийн зах зээлийн оролцогчдын эрсдэлийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын урсгал болон банкны салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлов.

- **Мөнгөний бодлого, макро эдийн засгийн орчин:**

2026 оны эхний хагас жилд геополитикийн эрсдэл болон инфляцын дарамт нь дэлхийн төв банкуудын мөнгөний бодлогын төлөвт голлох нөлөө үзүүлэв. АНУ-Ираны мөргөлдөөний улмаас эрчим хүчний үнэ өсөж, инфляцын дарамт нэмэгдсэнээр бодлогын хүүг бууруулах хүлээлт саарч, төв банкууд төсөөлж байснаас илүү хатуу мөнгөний бодлого баримтлах нөхцөлийг бүрдүүлсэн.

АНУ-ын Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүгээ өөрчлөлгүй хадгалсан боловч бодлого тодорхойлогчдын дунд цаашдын чиглэлийн талаар санал зөрүү хэвээр үлдэв. Европын Төв банк хадгаламжийн хүүгээ нэмэгдүүлж, шаардлагатай тохиолдолд мөнгөний бодлогыг цаашид чангатгах боломжтойг илэрхийлсэн бол Японы Төв банк бодлогын хүүгээ 25 суурь нэгжээр өсгөн 1.0 хувь болгож, 1995 оноос хойших хамгийн өндөр түвшинд хүргэлээ. Австралийн Нөөцийн банк мөн бодлогын хүүгээ 3.85 хувь болгон өсгөсөн бол Канадын Төв банк бодлогын хүүгээ 2.25 хувь дээр хадгалсан хэвээр байна.

Үүний зэрэгцээ БНХАУ-ын Ардын банк нээлттэй зах зээлийн үйл ажиллагаагаар дамжуулан зах зээлийн хөрвөх чадварыг идэвхтэй зохицуулсаар байв.

Олон улсын шинжээчдийн үнэлгээгээр геополитикийн эрсдэлээс үүдэлтэй инфляцын дарамт ойрын жилүүдэд дэлхийн бодлогын хүүг өмнөх төсөөллөөс дунджаар 0.5 нэгжээр өндөр түвшинд хадгалах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Энэхүү нөхцөл байдал нь олон улсын хөрөнгийн зах зээл дэх өгөөжийн хүлээлт, хөрөнгийн урсгал болон банкны хувьцааны үнэлгээнд үргэлжлэн нөлөөлөхөөр байна.

- **Зохицуулалтын орчны өөрчлөлт**

2026 оны эхний хагас жилд олон улсын банкны зохицуулалтын орчинд капиталын шаардлагыг оновчтой болгохын зэрэгцээ хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал болон валютын зах зээлтэй холбоотой хяналтыг эрчимжүүлэх чиг хандлага давамгайлав.

АНУ-д Холбооны Нөөцийн Сан, FDIC болон OCC байгууллагууд *Basel III Endgame* зохицуулалтын шинэчилсэн хувилбарыг олон нийтийн хэлэлцүүлэгт оруулсан бөгөөд уг зохицуулалт хэрэгжсэнээр томоохон банкуудын ашиглах боломжтой капиталын хэмжээ нэмэгдэж, зээл олголт болон хөрөнгийн удирдлагын үр ашиг сайжрах төлөвтэй байна.

Их Британид хиймэл оюун ухааны үйлчилгээ үзүүлэгчдэд тавих зохицуулалтыг өргөжүүлэх санал боловсруулагдсан бол Индонезийн Төв банк валютын зах зээлийн хэлбэлзлийг бууруулах зорилгоор гадаад валютын арилжаанд тавих хяналтаа чангатгав.

Эдгээр өөрчлөлтүүд нь банкны салбарын тогтвортой байдлыг хадгалахын зэрэгцээ шинээр бий болж буй технологийн болон зах зээлийн эрсдэлийг зохицуулалтын түвшинд илүү нарийн удирдах чиглэл рүү шилжиж байгааг харуулж байгаа юм.

- **Дүгнэлт**

2026 оны эхний хагас жилд дэлхийн банкны салбар геополитикийн тодорхой бус байдал, мөнгөний бодлогын өөрчлөлт, хиймэл оюун ухаан болон дижитал хөрөнгийн хөгжлийн нөлөөн дор үйл ажиллагаагаа эрчимтэй шинэчилсээр байв. Төв банкууд инфляцын эрсдэлд хариу арга хэмжээ авч мөнгөний бодлогоо болгоомжтой хэрэгжүүлсэн бол банкнууд технологийн шинэчлэл, стратегийн нэгдэл, хөрөнгийн удирдлагын бизнесийн өргөжилтөд түлхүү төвлөрөв. Эдгээр чиг хандлага нь дэлхийн санхүүгийн зах зээлд хөрөнгө оруулалтын урсгал, банкны үнэлгээ болон хөрөнгийн зах зээлийн төлөвт үргэлжлэн нөлөөлөхөөр байгаа бөгөөд банкны салбарын урт хугацааны өрсөлдөх чадварыг тодорхойлох үндсэн хүчин зүйл хэвээр байна.

2. Монгол Улсын макро эдийн засаг, санхүүгийн салбарын голлох өөрчлөлтүүд

2026 оны эхний хагас жилд Монгол Улсын эдийн засаг уул уурхайн экспортын өсөлтийн нөлөөгөөр тогтвортой өсөлтөө хадгаллаа. 2025 оны ДНБ-ий өсөлт 6.8%-д хүрсэн нь Монголбанкны өмнөх 5.8%-ийн төсөөллөөс өндөр үзүүлэлт болсон бөгөөд энэхүү өсөлтийн эрч 2026 оны I улиралд үргэлжилж, эдийн засаг өмнөх оны мөн үеэс 7.9%-иар өсөв. Энэхүү өсөлтийн 5 нэгж хувийг уул уурхайн салбар бүрдүүлсэн бөгөөд 2026 оны I улиралд зэсийн экспорт өмнөх оны мөн үеэс 135%-иар өссөн нь эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүчин болов.

Гадаад худалдааны хувьд Монгол Улс 2025 оны эцсийн байдлаар 858 сая ам.долларын худалдааны ашигтай ажиллаж, жилийн нийт зэсийн экспортын орлого 5.8 тэрбум ам.долларт хүрч түүхэн дээд түвшинд хүрсэн байна. Ашигт малтмал нийт экспортын 85%-ийг бүрдүүлж, экспортын 91% нь БНХАУ-д нийлүүлэгдэв. Үүний үр дүнд 2026 оны эхний хоёр сарын байдлаар нийт экспорт өмнөх оны мөн үеэс 52%-иар, БНХАУ-д хийсэн экспорт 55%-иар тус тус өссөн байна. Мөн 2026 оны зургаадугаар сард хоёр улсын худалдааны эргэлтийг 20 тэрбум ам.долларт хүргэх зорилтоо талууд дахин баталгаажуулсан. Нөгөө талаас, Дэлхийн банк дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал, эрчим хүчний үнийн өсөлт болон

геополитикийн эрсдэлийн нөлөөгөөр Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2026 онд 5.0% болж саарах төлөвтэй гэж үнэлсэн. Түүнчлэн инфляц ойролцоогоор 8.5% түвшинд хадгалагдах төлөвтэй байгаа бөгөөд алт, зэсийн үнийн өсөлт нь эдгээр эрсдэлийг тодорхой хэмжээгээр бууруулах хүчин зүйл болохыг онцолсон. Ийнхүү түүхий эдийн экспортын өсөлт нь улсын төсвийн орлого, гадаад валютын орох урсгал болон валютын албан нөөцийг нэмэгдүүлж, төртэй холбоотой байгууллагуудын санхүүгийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэв. Үүний үр дүнд банкны салбарын активын чанар, хөрвөх чадвар болон олон улсын хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжид эерэг нөлөө үзүүлэв.

■ **Инфляц ба мөнгөний бодлого**

2026 оны эхний хагас жилд инфляц Монголбанкны мөнгөний бодлогын гол сорилт хэвээр байлаа.

Жилийн эхэнд хэрэглээний үнийн индекс (ХҮИ) өмнөх оны мөн үеэс 7.5%-иар өсөж, 2024 оны 11 дүгээр сараас хойших хамгийн бага түвшинд хүрсэн бол гуравдугаар сард инфляц 6.5% болж буурч, Монголбанкны зорилтот түвшний дунд цэгт ойртсон нь өмнөх мөнгөний бодлогын үр нөлөө илэрч эхэлснийг харуулсан. Үүний үр дүнд Монголбанк гуравдугаар сарын мөнгөний бодлогын хорооны хурлаар бодлогын хүүг 12%-д хэвээр хадгалсан.

Харин тавдугаар сараас инфляц эргэн эрчимжиж, 11.2%-д хүрснээр 2023 оны тавдугаар сараас хойших хамгийн өндөр түвшинд хүрлээ. Энэхүү өсөлтөд махны үнэ өмнөх оны мөн үеэс 47%-иар, хүнс, согтууруулах бус ундааны үнэ 23%-иар өссөн нь голлон нөлөөлөв. Зургаадугаар сарын 24-ний мөнгөний бодлогын хорооны хурлаар Монголбанк бодлогын хүүг дахин 12%-д хэвээр үлдээж, цаашдын шийдвэр нь инфляцын төлөв, нийлүүлэлтийн хүчин зүйлс болон дотоод, гадаад эдийн засгийн нөхцөлөөс хамаарахаар байгааг онцолсон байна. Эдгээр нөхцөл байдлаас харвал Ойрхи Дорнодын геополитикийн хурцадмал байдлаас үүдэн эрчим хүчний үнэ өссөн нь импортын сувгаар дамжин Монгол Улсын инфляцад дарамт үзүүлж, дэлхийн олон улсын төв банкуудын нэгэн адил Монголбанкийг мөнгөний бодлогоо харьцангуй чанга түвшинд хадгалахад нөлөөлсөн.

Монголбанк 2026 оны эхний хагаст бодлогын хүүгээс гадна макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг ашиглан банкны системийн эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэв.

■ **Заавал байлгах нөөцийн шаардлагын өөрчлөлт**

2026 оны нэгдүгээр сард төгрөгийн эх үүсвэрт тавигдах заавал байлгах нөөцийн хэмжээг 13%-иас 14%, гадаад валютын эх үүсвэрийн нөөцийн хэмжээг 18%-иас 19% болгон нэмэгдүүлсэн. Энэхүү шийдвэрийг хэрэглээний зээлийн өсөлтөөс үүдэлтэй эрэлтийн инфляц болон гадаад орчны тодорхойгүй байдлын эрсдэлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлсэн билээ.

Мөн тавдугаар сард Монголбанкны Мөнгөний бодлогын хороо банкны гадаад санхүүжилтэд тавих шаардлагыг шинэчилж, 2026 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн олон улсын зах зээлээс татан төвлөрүүлсэн 360 хоногоос 3 жилийн хугацаатай гадаад валютын бонд болон зээлийн 25%-ийг заавал байлгах нөөцийн шаардлагад хамруулахаар шийдвэрлэсэн. Энэхүү арга хэмжээ нь банкны салбарын богино болон дунд хугацааны гадаад эх үүсвэрээс хэт хамаарах байдлыг бууруулахад чиглэж, банкны системийн хөрвөх чадвар, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, гадаад санхүүжилтийн бүтцийг сайжруулахад чиглэсэн бөгөөд хөгжиж буй орнуудын төв банкуудын валютын эрсдэлийн удирдлагын бодлоготой нийцэж байна.

■ **БНХАУ-ын Ардын банк болон Монголбанк хоорондын валютын своп хэлцлийн шинэчлэл**

2026 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Монголбанк болон БНХАУ-ын Ардын банк хоёр улсын үндэсний мөнгөн тэмдэгтийн своп хэлцлийг 15 тэрбум юань (ойролцоогоор 7.85 их наяд төгрөг) дүнтэйгээр 3 жилийн хугацаатай шинэчлэн байгууллаа. Энэхүү хэлцэл нь хоёр улсын санхүүгийн хамтын ажиллагааг

өргөжүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын юаниар санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлж, ам.долларын санхүүжилтийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм. Цаашлаад, Монгол Улсын нийт экспортын 90 гаруй хувь БНХАУ-д нийлүүлэгддэгийн зэрэгцээ хоёр улсын худалдааны эргэлтийг 20 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг талууд дэвшүүлээд байна. Энэ хүрээнд валютын своп хэлцлийг шинэчилсэн нь худалдааны төлбөр тооцоог юаниар хийх боломжийг нэмэгдүүлж, гүйлгээний зардал болон валютын ханшийн эрсдэлийг бууруулахын зэрэгцээ Монголын банкны системийн гадаад хөрвөх чадварыг дэмжих чухал хүчин зүйл болов.

▪ **Оюу Толгойн төсөл: Уул уурхайн санхүүжилт ба төсвийн орлогын төлөв**

Монгол Улсын ДНБ-ий 10 гаруй хувийг бүрдүүлдэг, эдийн засагт өдөрт дунджаар 23 тэрбум төгрөгийн өгөөж бий болгодог Оюу Толгойн төсөл 2026 оны эхний хагаст санхүү, бодлого болон улс төрийн хэд хэдэн чухал үйл явдлын төвд байв.

Гуравдугаар сард Засгийн газар хувь нийлүүлэгчийн зээлийн хүү болон менежментийн төлбөрийн нөхцөлийг дахин хэлэлцэх асуудлыг хөндөж, улмаар улс төрийн тодорхойгүй байдал үүссэн. Зургаадугаар сард Эрдэнэт үйлдвэрийн 773 сая ам.долларын зэс хайлуулах үйлдвэрийн төслийн сонгон шалгаруулалт урагшилж, дотоодын нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэв.

Зургаадугаар сарын сүүлээр Монгол Улсын Засгийн газар болон Rio Tinto компани хувь нийлүүлэгчийн зээлийн хүүгийн нөхцөлийг шинэчлэх талаар тохиролцоонд хүрснээр олон жилийн турш үргэлжилсэн тодорхойгүй байдлыг бууруулсан чухал ахиц гарлаа. Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төлөвлөгөө хэвээр хадгалагдаж байгаа бөгөөд Оюу толгойн уурхай 2028-2036 онд жилд дунджаар 500 мянган тонн орчим зэс үйлдвэрлэхээр төлөвлөж байна.

Оюу Толгойн хувь нийлүүлэгчийн зээлийн асуудлаарх тохиролцоо нь улсын төсөв болон төрийн санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна. Цаашид Засгийн газар төслийн 34%-ийн эзэмшлээс ногдол ашиг хүртэх боломж бүрдэх нь төсвийн орлогыг нэмэгдүүлж, улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахын зэрэгцээ төртэй холбоотой санхүүгийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм. Энэ нь урт хугацаанд банкны салбарын активын чанар, санхүүгийн тогтвортой байдал болон хөрөнгө оруулагчдын итгэлд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

▪ **Монголын банкны салбарын олон улсын хөрөнгийн зах зээл дэх санхүүжилтийн идэвхжил**

2026 оны эхний хагас жилд Монгол Улсын Засгийн газар болон арилжааны банкууд олон улсын хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах үйл ажиллагаагаа идэвхжүүлж, зээлжих зэрэглэлээ сайжруулсан нь хөрөнгө оруулагчдын итгэл нэмэгдэж байгааг илэрхийлэв.

Хоёрдугаар сард Монгол Улсын Засгийн газар 6 жилийн хугацаатай ам.долларын олон улсын бонд гаргахаар хөрөнгө оруулагчдын уулзалтыг зохион байгуулсан.

Мөн Голомт банк тавдугаар сард олон улсын зах зээлд 3 жилийн хугацаатай, 500 сая ам.долларын бонд гаргаж, Fitch агентлагаас B+ зэрэглэл авсан. Үүний дараа Moody's агентлагаас Голомт банкны урт хугацааны хадгаламж болон үнэт цаас гаргагчийн зэрэглэлийг мөн B2-оос B1 болгон ахиулж, төлөвийг "Тогтвортой" болгон шинэчилсэн нь банкны олон улсын зах зээл дэх нэр хүндийг нэмэгдүүлсэн үйл явдал боллоо.

Монголын банкны салбарын олон улсын хөрөнгийн зах зээл дэх идэвхжил нь түүхий эдийн экспортын өсөлт, макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн ахиц болон улсын зээлжих чадвар сайжирсантай уялдаж байна. Ийнхүү зээлжих зэрэглэлийн ахиц болон олон улсын бондын зах зээлд амжилттай оролцож буй

байдал нь банкнуудын урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх боломжийг нэмэгдүүлж, Монголын санхүүгийн салбар дэлхийн өрийн зах зээлтэй улам бүр нягт уялдаж байгааг харууллаа.

3. Голомт банкны 2026 оны тэргүүлэх чиглэлийн хүрээнд гүйцэтгэсэн ажлууд

Голомт банк 2026 оны хүрээнд хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэлийг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд уг ажлуудын хүрээнд эхний хагас жилд хийгдсэн онцлох үйл ажиллагааг танилцуулж байна:

- **Олон улсын хөрөнгийн зах зээлд эзлэх байр сууриа өргөжүүлэх**

Голомт банк олон улсын хөрөнгийн зах зээл дээр нээлттэй арилжаалагдах 3 жилийн хугацаатай, 7.95 хувийн купонтой ам.долларын бондыг Нью-Йоркийн хуулиар зохицуулагддаг 144A болон Reg S форматаар амжилттай гаргаж, Сингапурын хөрөнгийн биржид бүртгэснээр нийт 500 сая ам.долларын санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ. Уг бондын андеррайтераар JPMorgan, Deutsche Bank болон KGI зэрэг олон улсын зах зээлд нэр хүндтэй, томоохон хөрөнгө оруулалтын банкнууд ажилласан бөгөөд бондын бүтэц, үнэлгээ, хөрөнгө оруулагчдад чиглэсэн стратегийг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлж, бондод хөрөнгө оруулах захиалга 2.1 тэрбум долларыг давж амжилттай арилжаалагдлаа.

- **ЖДБ эрхлэгчдийг дэмжих, санхүүжилтийн таатай нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхайн бус эдийн засгийн тэлэлтийг дэмжих, санхүүжилтийг нэмэгдүүлэх**

Голомт банк өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийж, хэрэгжүүлж буй санаачилгаараа бизнесийн салбарыг тэр дундаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийг тал бүрээр дэмжин ажилладаг. Энэ хүрээнд жижиг, дунд бизнесүүдийг чадавхжуулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж ирсэн бөгөөд үүний нэг нь “Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг” (GIZ)-ийн “Эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих” (ICED) төсөлтэй хамтран хэрэгжүүлж буй “Экспортыг дэмжих хөтөлбөр” юм.

Цаашлаад Голомт банк олон улсад нэр хүндтэй, томоохон хөрөнгө оруулалтын сан болох Triple Jump байгууллагаас 5.8 сая ам.долларын урт хугацаат санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ. Уг санхүүжилт нь Голомт банкны бичил, жижиг, дунд бизнесийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, өрхийн аж ахуй, худалдаа, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэх юм.

- **Харилцагчын туршлагыг сайжруулах чиглэлд VIP, tailor-made үйлчилгээг өргөжүүлэх**

Голомт банк харилцагчийн болон байгууллагын онцлог, хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн хамгийн сайн шийдэл, цогц үйлчилгээг санал болгосоор ирсэн билээ. Үүний хүрээнд бид ВИП харилцагчдадаа дэлхийд тэргүүлэгч Mastercard, Visa брэндүүдийн давуу тал боломжуудыг хамтад нь авах боломжтой картуудыг санал болгож, түүний хамтаар нийт 26 консьерж үйлчилгээг нэвтрүүлээд байна. Цаашлаад орон нутгуудад хувийн банкны салбаруудыг нээн ВИП харилцагчдад үйлчилгээгээ улам ойртуулан “Хувь хүний хөрөнгө удирдлагын үйлчилгээ”, “ВИП консьерж үйлчилгээ” болон бусад ВИП бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл хүргэх ВИП харилцагчийн хүлээн авалтыг зохион байгууллаа.

- **Эрсдэлийн удирдлагад онцгой анхаарч дотоод үйл ажиллагааг тогтмол сайжруулах**

Голомт банкны зээлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн хүрээнд бичил бизнес судалгааны аргачлал сайжруулах, сайн зээлийн түүхтэй харилцагчид тавих шалгуурыг хөнгөвчлөн сайжруулалт хийснээр хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хүрээнд зээл олголтыг нэмэгдүүлж, бизнес эрхлэгчдийг дэмжиж ажилласнаар бичил бизнесийн зээлийн багц 58% өсөв. Зээлийн үйл ажиллагаа бүрэн системжсэнээр датанд суурилсан тайлан хөгжүүлэлтүүдийг гүйцэтгэж, шийдвэр гаргалтыг оновчтой удирдав. Мөн скорингийн аргачлалд ОУ-н аудитын байгууллагаар баталгаажуулалт хийлгэж, үүний үр дүнд суурилсан аргачлалын сайжруулалтуудыг хийж гүйцэтгэж ажиллалаа. Зээлийн скорингийн системд эргэн тест хийх

ажиллагааг автоматжуулснаар жилд 1 удаа хийгддэг байсан тестийг сар бүр автомат хянах, эрсдэлийг урьдчилж илрүүлэх, загвар сайжруулалтыг тухай бүр гүйцэтгэж эхлэв.

- **Монгол улсын эдийн засгийн ногоон шилжилтэд бодит хувь нэмэр оруулах**

Голомт банк Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилтууд болон уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход анхааран ажиллаж байгаагийн хүрээнд Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК)-ийн дэргэдэх “Ногоон арилжааны банкны эвсэл”-д нэгдлээ.

Түүнчлэн Голомт банк Азийн хөгжлийн банкттай (АХБ) хамтран жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, түүнчлэн эрчим хүчний хэмнэлт, хаягдал усны менежмент, тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэх төслүүдийг санхүүжүүлэх чиглэлд хамтын ажиллагаагаа эхлүүлэн 64 сая ам.долларын санхүүжилтийн гэрээ байгууллаа. Азийн хөгжлийн банкттай эхлүүлж буй энэхүү хамтын ажиллагаа нь Голомт банкны 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10 хувийг ногоон зээл болгох стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой, бодит дэмжлэг үзүүлэх томоохон төсөл бөгөөд 2025 оны байдлаар банкны нийт зээлийн багцад эзлэх ногоон зээлийн хэмжээ 4.9 хувьд хүрч, зах зээлийн 17.4 хувийг бүрдүүлж байна.

3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого
-----	--

Зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг.

Банк нь харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээнд зориулж төрөл бүрийн буцаах нөхцөлгүй болзошгүй өр төлбөр болон үүргийг хүлээдэг. Хэдийгээр эдгээр үүргүүдийг санхүүгийн байдлын тайланд тусгадаггүй ч эдгээр нь тодорхой хэмжээний эрсдэлийг агуулж байдаг тул Банкны нийт эрсдэлийн нэгээхэн хэсэг гэж үздэг.

Эдгээр хэрэглүүрүүдийн үндсэн зорилго бол харилцагчдад шаардлагатай үед нь санхүүжилтийн эх үүсвэрийг бэлэн байлгахад оршино. Баталгаа нь хэрэв харилцагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй тохиолдолд Банк өмнөөс нь төлбөрийг барагдуулах гэсэн цуцлагдах боломжгүй баталгаанууд бөгөөд эдгээр нь зээлтэй ижил төрлийн эрсдэл агуулдаг. Бичиг баримтын болон худалдааны аккредитив нь Банкнаас тодотгон заасан нөхцөлд гуравдагч этгээдэд тохиролцсон дүн хүртэлх хөрөнгийг авахыг харилцагчийн өмнөөс бичгээр зөвшөөрсөн үүрэг хүлээлт бөгөөд холбогдох бараа таваар буюу мөнгөн хадгаламжуудаар баталгаажсан байдаг тул зээлээс арай бага эрсдэлтэй байдаг.

Зээл, баталгаа болон аккредитив хэлбэрээр үүсгэсэн зээлийн шугамын ашиглаагүй хэсгээр Банк зээл олгох үүргийг хүлээдэг. Ашиглаагүй зээлийн шугамын хувьд харилцагч тухайн шугамыг ашигласан тохиолдолд л ашигласан зээлийн нийт хэмжээгээр Банк зээлийн эрсдэлд өртөх магадлалтай. Гэвч харилцагч тодорхой зээлийн нөхцөл, шалгуурыг хангасан тохиолдолд зээлийн шугам авах эрх үүсдэг тул Банкны хүлээж болох алдагдлын дүн ашиглагдаагүй байгаа зээлийн шугамаас бага байдаг.

Мянган төгрөгөөр		2026 оны 06 сарын 30
Олгосон санхүүгийн баталгаа		109,441,863
Олгосон гүйцэтгэлийн баталгаа		602,206,773
Аккредитив		141,728,633
Ашиглаагүй зээлийн шугам		832,022,588
Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг		1,685,399,857
Хасах нь: зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүргийн үнэ цэнийн бууралтын сангийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдал		(5,814,085)
Нийт зээлтэй адилтгах хөрөнгөд хамаарах үүрэг		1,679,585,772
4	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
2026.03.09-ны өдрийн хурлын шийдвэр		
1. Хэлэлцсэн асуудал : Холбогдох этгээдтэй хэлцэл байгуулах тухай		
Шийдвэр : Банкны холбогдох этгээдтэй байгуулах хэлцлүүдийг энэхүү Тогтоолын Хавсралт №1-т заасан нөхцөлөөр батлахыг зөвшөөрөв:		
- “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээг сунгах зориулалтаар хамтын ажиллагааны гэрээг байгуулах;		
- “Монгол масс медиа” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээг сунгах зориулалтаар хамтын ажиллагааны гэрээг байгуулах;		
- “Голомт капитал ҮЦК” ХХК-д зээлийн шугам олгох.		
Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.		
2026.03.16-ны өдрийн хурлын шийдвэр		
1. Хэлэлцсэн асуудал : Холбогдох этгээдтэй хэлцэл байгуулах тухай		

Шийдвэр : Банкны холбогдох этгээдтэй байгуулах хэлцлүүдийг энэхүү Тогтоолын Хавсралт №1-т заасан нөхцөлөөр батлахыг зөвшөөрөв:

- ӨБХ бүртгэлтэй хөрөнгийг “Цэцэнс холдинг” ХХК-д худалдах.

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

2026.04.14-ны өдрийн хурлын шийдвэр

1.Хэлэлцсэн асуудал : Холбогдох этгээдтэй хэлцэл байгуулах тухай

Шийдвэр : Банкны холбогдох этгээдтэй байгуулах хэлцлүүдийг энэхүү Тогтоолын Хавсралт №1-т заасан нөхцөлөөр батлахыг зөвшөөрөв:

- “Чимэгэ системс” ХХК-тай худалдан авалт хийх зориулалтаар худалдан авалтын гэрээ байгуулах;
- “Мөнгөнгүүр эмнэлэг” ХХК-д цалингийн санхүүжилт нэмэх зориулалтаар зээлийн шугам олгох;

Шийдвэрлэсэн нь : ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгөв.

5

Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл

“ГОЛОМТ БАНК ХК” ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

/2023 оны 12 сарын 31-ны байдлаар/

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаас гаргагч нь нийтэд хувьцааг санал болгох замаар татан төвлөрүүлэх 103,317,524,755 төгрөгөөс үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардлыг хассан цэвэр дүнгээр банкны үндсэн бүтээгдэхүүн болох зээл олголтыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн:

- Үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардлуудыг татан төвлөрүүлсэн хөрөнгөнөөс зарцуулна;
- Банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлснээр өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа үзүүлэлт сайжирч эрсдэлээр жигнэсэн актив буюу зээлийн багцын хэмжээг ойролцоогоор 790 гаруй тэрбум төгрөгөөр өсгөх боломж бүрдэж, ирээдүйн бизнесийн тогтмол өсөлтийг бий болгох гол суурь болно.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Банк 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд анхдагч зах зээлийн арилжаагаар хувьцааныхаа 10.09 хувь буюу 80,402,743 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1,285 төгрөгөөр нийтэд санал болгов. Захиалгын эрэлт өндөр байсан тул олон нийтэд санал болгосон хувьцааны 15 хувьтай тэнцэх хэмжээний буюу 12,060,411 ширхэг хувьцааг нэмэлтээр гаргаж, нийт 118,815,152,890 төгрөгийг /нийт хувьцааны 11.43 хувь/ олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн.

Нийт татан төвлөрүүлсэн 118,815,152,890 төгрөгийн зарцуулалт дараах байдалтай байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардал: 2.1 тэрбум төгрөг

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 12 сарын 06-ны өдрийн 1/4659 тоот зөвшөөрлөөр 2022 оны 12 сарын 08 ны өдөр Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн төвөөр дамжин нийт 118,815,152,890 төгрөг олон нийтээс татан төвлөрүүлсэн. Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс СТОУС дагуу үнэт цаас гаргахтай шууд

хамаарал бүхий зардлыг ААНОАТ-ын дүнгээр цэвэршүүлэн 2,103,028,206 төгрөгийг хасагдуулж цэвэр 116,712,124,684 төгрөгөөр банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэн бүртгэсэн.

2. Зээл олголт 116.7 тэрбум төгрөг Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт /Монголбанкны тайлангаар/

Үзүүлэлт (сая төгрөг)	11/30/2022	12/31/2022	31/12/2023	Өөрчлөлт (11/30/2022-12/31/2023)	
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө	673,839	811,978	940,109	266,270	40%
Өөрийн хөрөнгө	673,839	811,978	940,109	266,270	40%
Эрсдэлээр жигнэсэн актив	4,600,320	4,601,535	5,926,932	1,326,612	29%
I зэрэглэлийн Ө.Х-ийн хүрэлцээ (>9.0% + нөөц 4.0%)	14.65%	17.65%	15.86%	1.21%	
Нийт Ө.Х-ийн хүрэлцээ (>12.0%)	14.65%	17.65%	15.86%	1.21%	

2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөртэй харьцуулахад банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ тооцох нийт өөрийн хөрөнгө 266.3 тэрбум төгрөгөөр буюу 40 хувиар өсөж 940.1 тэрбум төгрөгт хүрсэн. Дээрх хугацаанд өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 1.21 нэгж хувиар нэмэгдэж банкны эрсдэл даах чадвар сайжирсанаар зээлийн багцын хэмжээг өсгөх боломж бүрдсэн хэвээр байна.

Банк 2022/12/09-өөс 2023/11/10-ны хооронд харилцагчдад нийт 7,854.6 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу эрсдэлтэй активын хамгийн багадаа 13 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх шаардлагатай байдаг. Нийт өөрийн хөрөнгийн 11.43 хувийг олон нийтэд нээлттэй хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгө эзэлж байх тул дээрх хугацаанд шинээр олгосон зээлийн 116.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн хөрөнгөөс санхүүжүүлсэн байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс санхүүжүүлсэн 116.7 тэрбум төгрөгийн зээлийг төлөвлөгөөний дагуу Том аж ахуйн нэгжийн бизнесийн зээлд 43.5 тэрбум /37.3 хувь/, ЖДБ болон иргэдэд олгосон бизнесийн зээлд 30.3 тэрбум /26.0 хувь/, Хэрэглээний зээлд 24.2 тэрбум /20.7 хувь/, Орон сууцны зээлд 18.7 тэрбум /16.0 хувь/ бүтцээр олгоод байна.

Банк 2023/11/10-ны байдлаар татан төвлөрүүлсэн хөрөнгөө бүрэн зарцуулж дуусгалаа.

6 | Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Хувьцааны тоо	Мөнгөн дүнгээр /мянган.төгрөг/	Хувь
1	Голомт Файнэншил Групп ХХК	645,040,527.00	161,260,131.750	79.77%
2	Свисс-Мо Инвестмэнт Эй Жи	42,120,816.00	10,530,204.00	5.21%
3	Бодь Интернэшнл ХХК	27,661,497.00	6,915,374.00	3.42%
4	Олон нийт	93,834,466.00	53,458,617.00	11.60%
Нийт		808,657,306.00	202,164,326.50	100.00%

Банк нийт гаргасан 808,657,306 ширхэг энгийн хувьцааг 2026 оны 06 сарын 30-ны байдлаар нийт 22,721 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Үүнд:

Голомт Файнэншил Групп ХХК	Голомт Файнэншил Групп ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр бизнесийн төвлөрсөн үйл ажиллагаагаа явуулдаг 100% Монголын хөрөнгө оруулалттай компани юм. Тус компани нь урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлого баримталдаг ба Голомт банкны энгийн хувьцаа эзэмшдэг.
Свисс-Мо Инвестмэнт Эй Жи	Тус хөрөнгө оруулалтын сангийн гол хувьцаа эзэмшигч нь Швейцари улсын иргэн, бизнесмэн, филантропч Урс И.Шварценбах. 2011 оны зургадугаар сард 20 сая ам.долларын хөрөнгө оруулснаар Голомт банкны 5.21 хувийн хувьцааг эзэмшсэн.
Бодь Интернэшнл ХХК	Бодь Интернэшнл ХХК нь үндэсний хөрөнгө оруулалттайгаар 1993 онд байгуулагдсан, томоохон групп компаниудын нэг бөгөөд өдгөө үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт, удирдлага, барилга, эрчим хүч, уул уурхай, амралт жуулчлалын салбаруудад үйл ажиллагаа амжилттай эрхэлж байгаа бөгөөд 10 гаруй охин компани болон хараат компаниудыг удирдан чиглүүлж байна.
Олон нийт	Голомт банк хувьцаагаа олон нийтэд санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг 2022 оны 11-р сард хийсэн. Голомт банкны IPO Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн том дүнтэй IPO болон хамгийн богино хугацаанд 114.4 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн гэх хоёр том амжилтыг бичиж үлдээсэн бөгөөд Монголын хөрөнгийн биржид нээлттэй арилжаалагдаж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Голомт банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4-р сарын 06-ны өдөр Шангри-Ла зочид буудлын хүлээн авалтын их танхимд 88.65 хувийн ирцтэйгээр танхим болон зайнаас хосолсон хэлбэрээр хурал зохион байгуулагдсан. Хурлын үр дүнд дараах асуудлуудыг хэлэлцэж баталсан.

Шийдвэрүүд:

1. Голомт банк ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг батлах тухай;
3. Голомт банкны дүрмийг батлах тухай

Мөн ХЭХ-аар дараах мэдээллийг танилцуулсан. Үүнд:

1. Голомт Банк ХК-ийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулга.
2. 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт.
3. 2025 оны аудитлагдсан санхүүгийн үр дүн - Хөндлөнгийн аудитын дүгнэлт.
4. 2025 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн Тогтоолыг танилцуулах.
5. 2025 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан. 2026 оны цалингийн төсөв.
6. Голомт Банкны дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай.

Төлөөлөн удирдах зөвлөл



Хатагтай
Ч.Мөнхцэцэг
ТУЗ-ийн дарга



Ноён
Д.Мөнхтөр
ТУЗ-ийн гишүүн



Ноён
Ж.Үнэнбат
ТУЗ-ийн гишүүн



Ноён
О.Ганжолоо
ТУЗ-ийн
гишүүн



Ноён
Б.Двайер
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Ноён
Александр
Пикер
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Ноён
Роберт
В.Ван
Свитен
ТУЗ-ийн
Хараат бус
гишүүн



Ноён
Ханс
Холзхакер
ТУЗ-ийн
Хараат бус
гишүүн



Ноён
Ронил Сүжан
ТУЗ-ийн
Хараат бус
гишүүн



Хатагтай
З.Солонго
ТУЗ-ийн
Нарийн
Бичгийн
дарга



Ноён
Б.Цэрэнпүрэв
Дотоод
аудитын
газрын
захирал

ТУЗ-ийн дэргэдэх хороод:

	Гишүүд	Албан тушаал
Эрсдэлийн удирдлагын хороо		Хорооны дарга

	Александр Пикер*	
		Хорооны гишүүн
	Роберт В.Ван Свитен*	
		Хорооны гишүүн
	Жэймс Б.Двайер*	
		Хорооны гишүүн
	Ч. Мөнхцэцэг	
		Хорооны гишүүн
	Ж.Үнэнбат	
Аудитын хороо		Хорооны дарга
	Жэймс Б.Двайер*	

	 Александр Пикер*	Хорооны гишүүн
	 Ч. Мөнхцэцэг	Хорооны гишүүн
	 Д.Мөнхтөр	Хорооны гишүүн
	 Ханс Холзхакер*	Хорооны гишүүн
Засаглал, ёс зүй, цалин урамшууллын хороо	 Жэймс Б.Двайер*	Хорооны дарга

Нэр дэвшүүлэх хороо	 Александр Пикер*	Хорооны гишүүн
	 Ч. Мөнхцэцэг	Хорооны гишүүн
	 Александр Пикер*	Хорооны дарга
	 Роберт В.Ван Свитен*	Хорооны гишүүн
	 Ч. Мөнхцэцэг	Хорооны гишүүн

Удирдлагын баг



А.Одонбаатар
Гүйцэтгэх захирал



Г.Ганболд
Ерөнхийлөгч



Т.Отгон
Эрсдэл хариуцсан захирал



М.Сайнбилэг
Мэдээлэл технологи
хариуцсан захирал



С.Мөнхтуяа
Санхүүгийн удирдлагын
газрын захирал



М.Наранхүү
Зээлийн газрын захирал



Ц.Байгалмаа
Жижиг, дунд банкны
газрын захирал



Б.Содболор
Нөөцийн удирдлагын
газрын захирал



Б.Сугар-Эрдэнэ
Байгууллагын банкны
газрын захирал



Б.Энхзаяа
Олон улсын банкны
газрын захирал



Г.Уянга
Хүний нөөцийн
удирдлагын газрын
захирал



Б.Зориг
Маркетинг, олон нийттэй
харилцах газрын захирал



Г.Мандах
Харилцагчийн
бүртгэлийн газрын
захирал



Ё.Пүрэвбат
Бүртгэл тооцооны газрын
захирал



Х.Пүрэвдорж
Захиргааны газрын
захирал



З.Сугар
Иргэдийн банкны газрын
захирал



О.Батцэнгэл

Дижитал банкны газрын
захирал




А.Нямсүрэн

Харилцагчийн
үйлчилгээний газрын
захирал



Б.Энхтүвшин

Зээл цуглуулах газрын
захирал



Ж.Оюун

Дижитал шилжилтийн
газрын захирал



Д.Баяржаргал

Мэдээлэл технологийн
газрын захирал

7 | Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИДТАЙ ХАРИЛЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Голомт банкны 2026 оны тэргүүлэх стратегийн хүрээнд мэдээллийн ил тод байдлыг эрхэмлэн Хөрөнгө оруулагчдын харилцааг бэхжүүлэх, олон улсын стандартыг мөрдөн ажиллах чиглэл тусгагдсан байгаа билээ.

Үүний хүрээнд банкны Хөрөнгө оруулагчидтай харилцах чиг үүрэг нь банк болон хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, шинжээчид, санхүүгийн зах зээлийн бусад оролцогч талуудын хоорондын харилцааг үр нөлөөтэйгээр удирдан зохион байгуулж, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг хангах үндсэн зорилготой ажилладаг.

Тус чиг үүрэг нь банкны стратеги, санхүүгийн гүйцэтгэл, үйл ажиллагааны үр дүн болон цаашдын төлөвлөгөөтэй холбоотой мэдээллийг үнэн зөв, цаг тухайд нь хүргэх замаар хөрөнгө оруулагчдын итгэлцлийг бэхжүүлж, банкны нэр хүнд, үнэлгээг хөрөнгийн зах зээлд тогтвортой өсгөхөд чиглэдэг билээ. Мөн хөрөнгө оруулагчид болон зах зээлийн оролцогчдын санал, хүлээлтийг банкны удирдлагад тогтмол хүргэж, стратегийн шийдвэр гаргалтыг мэдээллээр хангах замаар урт хугацааны үнэ цэнэ болон хувьцаа эзэмшигчдийн өгөөжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд банк нь хөрөнгө оруулагчидтай харилцах үйл ажиллагаагаа олон улсын шилдэг туршлага, мэдээллийн ил тод байдлын зарчимд нийцүүлэн хэрэгжүүлж, санхүүгийн тайлагнал, хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга, уулзалт, олон нийтэд мэдээлэл түгээх сувгуудыг тогтмол ашиглан хоёр талын идэвхтэй харилцааг ханган ажиллав. Мөн дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид,

шинжээчидтэй нэг бүрчилсэн (one-on-one) болон бүлэг уулзалтуудыг зохион байгуулж, банкны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэсэн.

Банк нь бүх хөрөнгө оруулагчдад мэдээллийг тэгш, хүртээмжтэй хүргэх зарчмыг баримталж, дараах үндсэн сувгуудаар дамжуулан харилцааг хэрэгжүүлдэг. Үүнд:

- **IR Календарь (Investor Relations Calendar)** - Санхүүгийн тайлагнал болон хөрөнгө оруулагчдад чиглэсэн үйл ажиллагааны нэгдсэн хуваарь.
- **Earnings Call** - Удирдлагын зүгээс улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнг танилцуулж, хөрөнгө оруулагчид, шинжээчдийн асуултад хариулдаг цахим уулзалт.
- **Гүйцэтгэх захирлын захидал** - Банкны стратеги, гүйцэтгэл болон ирээдүйн төлөвийн талаарх удирдлагын байр суурийг илэрхийлсэн мэдээлэл.
- **Удирдлагын хэлэлцүүлэг ба шинжилгээ (Management Discussion and Analysis)** - Санхүүгийн үр дүн, салбарын нөхцөл байдал, эрсдэл болон цаашдын төлөвийн талаарх дэлгэрэнгүй тайлбар, дүн шинжилгээ.
- **Analyst Day** - Санхүүгийн шинжээчид болон институцын хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга, хэлэлцүүлэг.

Цаашид банк нь олон улсын тайлагнал, мэдээллийн ил тод байдлын стандартыг тууштай мөрдөж, хөрөнгө оруулагчдын мэдээллийн хэрэгцээг хангах, итгэлцлийг нэмэгдүүлэх, улмаар хөрөнгийн зах зээл дэх байр сууриа бэхжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулан ажиллах болно.

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

“Голомт банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн 2026 оны 2-р сарын 13-ны өдрийн 00/01 тоот тогтоолоор компанийн 2025 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 80 /наян/ төгрөг буюу нийт 64,692,584,480.00 /жаран дөрвөн тэрбум зургаан зуун ерэн хоёр сая таван зуун наян дөрвөн мянга дөрвөн зуун наян/ төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахаар шийдвэрлэсэн. Тэрээр уг ногдол ашиг олголтыг Монголбанкнаас зөвшөөрөл олгосны дагуу 2026 оны 4-р сарын 27-ний өдөр татвар суутгасны дараах дүнгээр “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” рүү шилжүүллээ.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр : Залаа-Уул Солонго

Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

Гарын үсэг:



Он, сар, өдөр: 2026.07.20



ГОЛОМТ БАНКНЫ АУДИТЫН ХОРОО GOLOMT BANK AUDIT COMMITTEE

2026 оны 07 сарын 03

Дугаар 03/07

Улаанбаатар хот

Цахим хурлын системээр дараах гишүүдийн ирцтэй хуралдав:

Аудитын хорооны дарга, Хараат бус гишүүн	Жэймс Б.Двайер
Аудитын хорооны гишүүн, ТУЗ-ийн дарга	Ч.Мөнхцэцэг
Аудитын хорооны гишүүн Хараат бус гишүүн	А.Пикер
Аудитын хорооны гишүүн Хараат бус гишүүн	Х.Холзхакер
Аудитын хорооны гишүүн	Д.Мөнхтөр
Аудитын хорооны НБД, ТУЗ-ийн НБД	З. Солонго
Бусад ажиглагчаар оролцогчид:	
ТУЗ-ийн гишүүн	О. Ганжолоо
Гүйцэтгэх захирал	А.Одонбаатар
Мэдээллийн технологи хариуцсан захирал	М.Сайнбилэг
ТУЗ-ийн хуралд танилцуулга хийхээр оролцогчид:	
Эрсдэл хариуцсан захирал	Т.Отгон
Дотоод аудитын газрын захирал	Б.Цэрэнпүрэв
Санхүүгийн удирдлагын газрын захирал	С.Мөнхтуяа
ДАГ Ерөнхий аудитын хэлтсийн захирал	Б.Хишигжаргал
ДАГ-ын ахлах аудиторрууд	

The meeting was held on 03th of July, 2026 via electronic voting system.

Meeting members:

Chair of Audit committee, Independent member	James B. Dwyer
Member of Audit committee, Chairperson of the Board of Directors	Ch.Munkhtsetseg
Independent member of Audit committee	Alexander Picker
Independent member of Audit committee	Hans Holz hacker
Member of Audit committee	D.Munkhtur
Audit Committee Secretary, Board secretary	Z.Solongo

Other participants:

Member of BoD	O.Ganjoloo
Chief executive officer	A.Odonbaatar
Chief risk officer	T.Otgon
Chief information officer	M.Sainbileg
Director of IAD	B.Tserenpurev
Director of FMD	S.Munkhtuya
Director of General Audit Department, IAD	B.Khishigjargal
Senior Auditors of the IAD	

Хурлын ирц: 100%

Meeting quorum: 100%

Хуралдсан өдөр, цаг: 2026.07.03-ны өдөр, 10:00-14:00

Date: July 03,2026, 10:00-14:00

Хэлэлцэх асуудлын жагсаалт:

1. Санхүүгийн үр дүн /2026 оны 6 сарын 30-ны байдлаар/

Discussed issues:

1. Financial results /as of June 30, 2026/

Танилцуулга 1. Санхүүгийн үр дүн /2026 оны 6 сарын 30-ны байдлаар/-г Гүйцэтгэх захирал А.Одонбаатар болон СУГ-ын захирал С.Мөнхтуяа нар танилцуулав.



ГОЛОМТ БАНКНЫ АУДИТЫН ХОРОО GOLOMT BANK AUDIT COMMITTEE

Баланс

- Харилцагчийн эх үүсвэр төсвөөс 1.4 их наяд төгрөгөөр давсан
- Бондын санхүүжилт төсвөөс 978 тэрбум төгрөгөөр давсан
- Цэвэр зээл төсвөөс 308 тэрбум төгрөгөөр давсан
- Нийт зээл 155 тэрбум төгрөгөөр давсан
- Балансын гол харьцаа үзүүлэлтүүд төсөвлөснөөс сайн гүйцэтгэлтэй

Орлогын тайлан

- Эрсдэлийн сан, үнэлгээний зардал 50.3 тэрбум төгрөгөөр төсөвлөснөөс бага буюу сайн гүйцэтгэлтэй
- Своп 97.4 тэрбум төгрөгөөр төсвөөс давсан
- Арилжааны ашиг 13.3 тэрбум төгрөгөөр төсвөөс давсан
- Үйл ажиллагааны зардал 13 тэрбум төгрөгөөр төсвөөс бага буюу сайн гүйцэтгэлтэй

Presentation 1. Financial results / as of June 30, 2026/ were presented by A.Odonbaatar Chief executive officer, S.Munkhtuya, Director of Financial Management Division.

Balance sheet:

- Customer fund above budget by ₮1.4 trillion
- Bond fund above budget by ₮978 billion
- Net loans above the budget by ₮308 billion
- Total loans above the budget by ₮155 billion
- All balance sheet ratios better than budget

Income statement:

- Provision & valuation expense below budget by ₮50.3b
- SWAP impact / +₮97.4b/ above the budget
- Trading / +₮13.3b / above the budget
- Operating expense below budget by ₮13b

Шийдвэрлэсэн нь:

Голомт банкны 2026 оны хагас жилийн санхүүгийн үр дүнтэй танилцан баталгаажуулав.

Resolved:

Reviewed in detail and assured the Golomt Bank 2026 half yearly financial results.

Тэмдэглэл/шийдвэр хөтөлсөн:

Minutes/resolution recorded by:

АУДИТЫН ХОРООНЫ НБД
SECRETARY OF AUDIT COMMITTEE

З.СОЛОНГО
Z.SOLONGO

Тэмдэглэл/шийдвэр баталсан:

Minutes/resolution approved by:

АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА
CHAIR OF AUDIT COMMITTEE

ЖЭЙМС Б.ДВАЙЕР
JAMES B. DWYER